



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 12/02

Арвайхээр


Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн дүн, 2020 оны үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2."а", Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 92.3 хувьтай буюу "үр дүнтэй- зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн, үр дүн гарсан" гэж үзсүгэй.
2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг 4 бодлого зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр хавсралтаар баталсугай.
3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, бүтэн жилээр дүгнэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд илтгэхийг аймгийн Засаг дарга /Г.Ганболд-д даалгасугай.

ДАРГА  А.ИШДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
12/02 дугаар тогтоолын хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН НЙГЛЭЛ

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
НЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРДЭС БАЯЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Байгаль орчныг хамгаалах, тэнцвэрт байдлыг хангах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, тогтвортой аялал жуулчлал, ногоон хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.						
1.1. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗРЫН ХАРИЛЦАА						
<i>Зорилт 1. Экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, бохирдол хомсдол бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.</i>						
1	ЗДҮАХ-ийн 1.1.2.6 дахь заалт	Сумдын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	5 сум	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар /цаашид БОАЖГ гэх/
2	ЗДҮАХ-ийн 1.1.3.8 дахь заалт	Сумдад хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландшафлын аргаар дарж, Арвайхээр суманд хог тээврийн автомашины парк шинэчлэл хийх	Парк шинэчлэл хийгдсэн байна.	Сумдын төвүүдэд ангилан ялгах цэг байгуулж, аймгийн төвд боловсруулах цэг байгуулсан байна.	Улс, орон нутгийн төсөв хөтөлбөр	Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХОХБТХ гэх/, БОАЖГ, Сумдын ЗДТГ

3	ЗДҮАХ-ийн 1.1.1.4 дэх заалт	Сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан шахмал түлшээр хангаж, түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, төвлөрсөн халаалтын зуухнуудад дэвшилтэт технологи турших замаар агаарын бохирдлыг бууруулах	50 хувь хүртэл	Аймгийн төвийн агаарын бохирдол буурна.	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ, БОАЖГ, Арвайхээр сумын ЗДТГ
4	ЗДҮАХ-ийн 1.1.3.4 дэх заалт	Цэвэр технологи, байгальд эзлтэй материал, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, техник, технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих	Ирүүлсэн төслийн тоогоор	Мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ, БОАЖГ
5	ЗДҮАХ-ийн 1.2.1.7 дахь заалт	Нүүдлийн соёл иргэншил, ахуй амьдралыг харуулсан аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг бүс нутгийн хэмжээнд тогтмол хугацаанд зохион байгуулах	Арга хэмжээ 4	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дотоод, гадаад жуулчдын тоо нэмэгдсэн байна.	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар /цаашид БСУГ гэх/, БОАЖГ
6	ЗДҮАХ-ийн 1.1.2.9 дэх заалт	Эрдэнэзуу, Хархорин музейн хооронд аялал жуулчлалын гудамж байгуулж, тохижуулах	Тохижилтын ажлын гүйцэтгэлээр	Аялал жуулчлалын гол бүс нутгийн дэд бүтцийг сайжруулсан байна.	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ, БОАЖГ
7	ЗДҮАХ-ийн 1.1.3.6 дахь заалт	Иргэд, өсвөр үеийнхэнд тогтвортой хөгжил, ногоон хөгжил, байгаль орчны боловсрол, эрх зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	19 удаа	Иргэд байгаль орчноо хамгаалах зөв дадал, хэвшилд суралцсан байна.	Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	БОАЖГ, Холбогдох сумдын ЗДТГ
8	ЗДҮАХ-ийн 1.2.1.1 дэх	Монгол Улсын Төв цэг, Түйн голын Цагаан эрэг дэх хөшөөг	Тохижилтын ажлаар	Төв цэг, Түйн голын Цагаан эрэг дэх	Улсын төсөв	ХОХБТХ, БОАЖГ,

	заалт	сэргээн засварлах, тохижилтын ажлыг хийх		хөшөөг сэргээн засварласан байна.		Сумын ЗДТГ
Зорилт 2. Газар зохион байгуулалтыг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлнэ.						
9	ЗГҮАХ-ийн 2.81 дэх заалт	Газар зүйн нэрийн тодруулалтыг хийх, аймгийн газар нутгийг газар ашиглалтын зориулалтаар нь тооллого явуулж мэдээллийн санд бүртгэх	Аймгийн хэмжээнд	Газар усны нэрийн зурагт ороогүй нэрсийг тодруулах тооллого хийгдсэн байна.	Орон төсөв нутгийн	Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /цаашид ГХБХБГ гэх/, сумдын ЗДТГ
10	ЗГҮАХ-ийн 2.80, 2.81 дэх заалт	Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох	Аймгийн хэмжээнд	Нэгдсэн мэдээллийн сан бий болсон байна.	Орон төсөв нутгийн	ГХБХБГ
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Орон нутгийн түүхий эд, гадаад зах зээлд түшиглэсэн импортыг орлох экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нэмүү өртөг шингээсэн кластер хэлбэрийн инновацид суурилсан үйлдвэрүүдийг хөгжүүлэх замаар аймгийн эдийн засгийг тэлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ.						
2.1. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН САЛБАР						
Зорилт 3. Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулж, төсвийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар үр өгөөжийг нь дээшлүүлэх, байгалийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, гадаад харилцааг эдийн засагжуулах бодлого баримтлан ажиллах, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар аймгийн эдийн засгийг тэлэх бодлогыг авч хэрэгжүүлнэ.						
11	ЗДҮАХ-ийн 2.1.7.2 дахь заалт	Нийгмийн бүх салбарт даатгалын системийг нэвтрүүлж, иргэдийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх	Сургалт, сурталчилгааны тоогоор	Иргэд мэдээллээр хангагдсан байна.	Орон төсөв нутгийн	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс
12	ЗДҮАХ-ийн 2.1.6.2 дахь заалт	Татварын байгууллага болон арилжааны банкуудын хамтын ажиллагаагаар татварын төлбөр, тооцооны цахим системийг нэвтрүүлэх	Аж ахуйн нэгжийн тоогоор	Татварын төрөл бүрд Qray, интернэт банк ашигладаг болно.	Улсын төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтэс /цаашид ТХ гэх/
13	ЗДҮАХ-ийн	Орон нутгийн татварын баазыг	Өмнөх оны	Нэмэгдсэн өртгийн	Орон нутгийн	Татварын

	2.1.6.3 дахь заалт	нэмэгдүүлж, төсвийн орлогыг одоо байгаа түвшингээс бууруулахгүй байх	татварын орлогын дүнгээр	албан татвар суутган төлөгч нэмэгдсэн байна.	төсөв	хэлтэс
14	ЗДҮАХ-ийн 2.1.7.3 дахь заалт	Өрхийн болон хувь хүний санхүүгээ удирдах аргачлалыг бүх нийтэд түгээн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Санхүүгээ удирдах аргачлалын сургалтууд хийгдсэн байна.	Орон нутгийн төсөв	СТСХ
15	ЗДҮАХ-ийн 2.1.4.1 дэх	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад дотоодын аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, орон нутгаас ажиллах хүч авсан аж ахуйн нэгжүүдийг дэмжих	Аж ахуйн нэгжийн тоогоор	Дотоодын аж ахуйн нэгжийн оролцоо, дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний эзлэх хувь нэмэгдэнэ.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар /цаашид ОНӨГ гэх/
16	ЗДҮАХ-ийн 2.1.3.5 дахь	Бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, зөвлөн туслах, дүгнэх, хамтран хяналт, үнэлгээ хийх ажлыг гэрээгээр болон тусгай удирдамжийн дагуу гүйцэтгэх	Хяналт үнэлгээний тоогоор	Хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдсан байна.	Орон нутгийн төсөв	ОНӨГ
17	-	Хүн ам, орон сууц, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах	Тооллогын үр дүнгээр	Тооллого хийгдсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	Статистикийн хэлтэс
18	ЗДҮАХ-ийн 2.1.2.1 дахь заалт	Сумдын бие даан хөгжих эдийн засгийн чиглэлийг тухайн сумдаар тодорхойлуулж, аймгаас бодлогын дэмжлэг үзүүлэх	19 сум	Сумдын бие даан хөгжих эдийн засгийн чиглэлийг тогтоосон байна.	Улс, орон нутгийн төсөв	ХОХБТХ
19	ЗДҮАХ-ийн 2.1.1.3 дахь заалт	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн "Өвөрхангай аймгийн хэтийн зорилт"-ыг боловсруулах	1	Бодлогын баримт бичиг батлагдсан байна.	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ

Зорилт 4: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, бизнесийн орчинг

сайжруулна.							
20	ЗДҮАХ-ийн 2.2.1.5 дахь	Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	Санхүүжилтээр	Үйлдвэр эрхлэгчид зээлэнд хамрагдсан байна.	Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХХААГ, сумдын ЗДТГ	
21	ЗДҮАХ-ийн 2.2.2.8 дахь	Үйлдвэр эрхлэгчдийг бусад улс, хот, аймаг, сумдад туршлага судлахад дэмжлэг үзүүлж, зохион байгуулалттай оролцуулах	Туршлага судалсан байна.	Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	ХОХБТХ, ХХААГ, сумдын ЗДТГ, аймгийн ХАҮТ	
22	ЗДҮАХ-ийн 2.2.2.8 дахь	Аймгийн хэмжээнд "Орон нутгийн үйлдвэрлэл-борлуулалтыг дэмжье-2020" аян зохион байгуулах	Аймгийн хэмжээнд	Үйлдвэрлэлт, борлуулалт нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсөв	ХХААГ, ОНӨГ, СЗДТГ, байгууллагууд	
23	ЗДҮАХ-ийн 2.2.1.5 дахь заалт	Хархорин сум дахь гурилын үйлдвэрийг орон нутгийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах	1 үйлдвэр	Гурилын үйлдвэрийг орон нутгийн өмчид шилжүүлсэн байна.	Орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж	ХХААГ, ОНӨГ	
24	ЗДҮАХ-ийн 2.2.2.6 дахь заалт	Хүнсний салбарын 90 жилийн ойн хүрээнд аймгийн хүнсчдийн уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтуудыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	Салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэсэн байна.	Орон нутгийн төсөв	ХХААГ, Мэргэжлийн холбоод	
25	ЗДҮАХ-ийн 2.4.3.3 дахь заалт	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах-зуучлах худалдааны төвийг Арвайхээр суманд байгуулахад дэмжлэг үзүүлэх	Худалдааны төв 1	Худалдааны төв байгуулагдсан байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө	ХОХБТХ, ХХААГ	
26	ЗДҮАХ-ийн 2.3.1.5 дахь заалт	Баянтээгийн нүүрсний уурхайн хагас коксжсон шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээгээр	Дулаан үйлдвэрлэлийн зуухнууд, айл өрхийг шахмал түлшээр хангасан байна.	Улс, орон нутгийн төсөв	ХОХБТХ, Баянтээг ХК	
2.3. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР							
Зорилт 5. Байгаль цаг уурын нөхцөлд зохицсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн, бэлчээр ашиглалтыг сайжруулж, мал амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний чанарыг сайжруулж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.							
27	ЗДҮАХ-ийн	Биотехнологийн ололтыг	115.5 мянган мал	Ашиг шимийн	Улс, орон	ХХААГ,	

	2.4.1.2 дахь заалт	ашиглан бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийн мал бий болгох судалгааны ажил явуулах		түвшинг тогтоосон байна.	нутгийн төсөв	Сумдын ЗДТГ
28	"Монгол мал" төлөвлөгөөний 2.3.4 дэх заалт	Мал сүрэгт үзлэг ангилалт хийж ээмэгжүүлэн, бүртгэл мэдээллийн санд хамруулах, ээмэгжүүлэлтийн ач холбогдлын талаар малчдад сурталчлах, үржил, селекцийг сайжруулж, цөм сүрэг бүрдүүлэх	140.0 мянган малыг хамруулах	Малын гарал үүсэл тодорхойлогдсон байна.	Улс, орон нутгийн төсөв	ХХААГ, Сумдын ЗДТГ
29	ЗДҮАХ-ийн 2.4.1.3 дахь заалт	Эрчимжсэн үхрийн болон гахай, тахиа, зөгийн аж ахуйг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	19 сум	Туслах аж ахуйн бүтээгдэхүүн нэмэгдсэн байна.	Улс, орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр	ХХААГ, сумдын ЗДТГ
30	ЗДҮАХ-ийн 2.4.1.5 дахь заалт	Бэлчээрийн хөнөөлт хортон мэрэгч үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах	20.0 мянган га-аас доошгүй талбай	Үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	ХХААГ
31	ЗДҮАХ-ийн 2.4.4.4 дэх заалт	Залуу малчдыг бэлтгэх, давтан сургах ажлын хүрээнд сум бүрээс малчдыг оролцуулан Өвөр монголд туршлага судлуулах	Сум бүрээс залуу малчин хамрагдсан байна.	Малчид гадаадын тэргүүн туршлагаас суралцсан байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХХААГ
32	ЗДҮАХ-ийн 2.4.5.1 дэх заалт	Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж, сумдад хүнсний ногооны төрөлжсөн зоорь, энгийн болон механикжсан, өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	Зоорь, хүлэмжийн тоогоор	Тариаланчдын зардал буурч, бүтээгдэхүүний нэр төрөл, хөрсний үржил шим нэмэгдэнэ.	Улс, орон нутгийн төсөв, төслийн хөрөнгө	ХХААГ
33	МЭҮЧСХөтөлбөр 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.5 дахь заалт	Гэрийн тэжээвэр амьтдаас халдварладаг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх бүртгэлжүүлэх, туулгалт, бруцеллэзын	Сумын төвүүдийн нохойг хамруулах	Нохойны бруцеллэз, паразиттах өвчний тархалтын байдлыг тогтоож, цаашид хэрэгжүүлэх арга	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын ЗДТГ

		шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, зооноз өвчний гаралт, тархалтыг бууруулах		хэмжээг оновчтой төлөвлөсөн байна.		
2.4. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, ТЭЭВЭР ЛОЖИСТИК						
Зорилт 6. Орон нутагтаа тав тухтай орчин, нөхцөлд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.						
34	ЗДҮАХ-ийн 2.5.2.9 дэх заалт	Арвайхээр, Хархорин сумдын 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээнд шинэчлэл хийх, ухаалаг тоолуур тавих, Есөнзүйл сумын төвөөс орон нутгийн А-0301 авто зам хүртэл 10 км, Бат-Өлзий сумын цанын баз хүртэл цахилгаан дамжуулах агаарын шугам татах, Хайрхандулаан, Өлзийт, Гучин-Ус сумдын 0.4 кВт-ын цахилгааны шугамын өргөтгөл хийх	Хэрэгжилтийн хувиар	Цахилгаан хангамж нэмэгдэж, цахилгаан түгээлтийн алдагдал буурна.	Улс, орон нутгийн төсөв, Дэлхийн банкны төсөл	ХОХБТХ, ЭБЦТС ТӨХК
35	ЗДҮАХ-ийн 2.5.2.9 дэх заалт	Арвайхээр суманд шинээр байгуулагдах дулаан дамжуулах төвүүдэд холбогдох 2 дугаар контурын шугамын зураг, төсөл боловсруулах, шугамын ажлыг барьж эхлэх	Хэрэгжилтээр	Зураг төсөл боловсруулж, ажил эхэлсэн байна.	Улсын төсөв	ХОХБТХ
36	ЗДҮАХ-ийн 2.5.2.12 дахь заалт	Хархорин сумын төвийн гэрэлтүүлэг, тохижилтыг нэмэгдүүлэх	Гэрэлтүүлэг, тохижилт нэмэгдсэн байна.	Ая тухтай орчин бүрдсэн байна.	Улсын төсөв	ХОХБТХ
37	ЗДҮАХ-ийн 2.5.2.12 дахь заалт	Нийтийн эзэмшлийн зам талбайн шаардлагатай газруудад замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохиог нэмэгдүүлэх	Гэрэл дохио, замын тэмдэг, тэмдэглэгээний тоогоор	Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн байна	Орон нутгийн төсөв, ОНХС	ХОХБТХ
38	ЗДҮАХ-ийн 2.5.2.10 дахь заалт	Алслагдсан багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох асуудлыг судалж, холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх	Зохион байгуулсан ажлаар	Судалж шийдвэрлэсэн байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ
39	ЗДҮАХ-ийн	Есөнзүйл сумын төрийн	Үйл ажиллагааны	Сумын төвийг цэвэр	Орон нутгийн	ХОХБТХ,

	2.5.2.7 дахь заалт	байгууллагуудыг цэвэр усны хангамж, бохир усны цооногт холбох ажлыг эхлүүлэх, бохир ус сорох автомашинтай болох	хэрэгжилтээр	усны хангамж, бохир усны цооногт холбох ажил эхэлсэн байна.	төсөв, Төсөл хөтөлбөр	Есөнзүйл сумын ЗДТГ
40	ЗДҮАХ-ийн 2.5.2.7 дахь заалт	Баянгол суманд усан сан барих, Сант сумын усан хангамжийг сайжруулах, шугам сүлжээг өргөтгөх	Ажлын гүйцэтгэлээр	Усан хангамж нэмэгдсэн байна.	Улсын төсөв	ХОХБТХ, Холбогдох сумдын ЗДТГ
41	-	Бүрд сумын бизнес хөгжлийн төвийг засварлах	Ажлын гүйцэтгэлээр	Засвар хийгдсэн байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ, Бүрд сумын ЗДТГ
Зорилт 7. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулна.						
42	ЗДҮАХ-ийн 2.5.3 дахь заалт	Арвайхээрээс Улаанбаатар чиглэлийн 60 км авто замын засвар, шинэчлэл хийх	60 км замыг засварлах	Зураг төсөл боловсруулагдаж ажил эхэлсэн байна.	Азийн хөгжлийн банк	ХОХБТХ
43	ЗДҮАХ-ийн 2.5.1.4 дэх заалт	Орхон голын Онгоцтойн амны болон Цагаан голын төмөр бетон гүүрүүдийг барьж ашиглалтад оруулах, Бат-Өлзий сумын төв, сумын төвөөс Онгоцтойн амны гүүр хүртэлх хайрган болон асфальтан хучилттай автозамыг барьж дуусгах	Зам, төмөр бетон гүүрүүд баригдсан байна.	Сумын төв, сумын төвөөс Онгоцтойн амны гүүр хүртэлх авто замууд болон гүүр ашиглалтад орсон байна.	Улс, орон нутгийн төсөв	ХОХБТХ
44	ЗДҮАХ-ийн 2.5.2.8 дахь заалт	Уянга сумын үерийн ус зайлуулах байгууламжийн зураг төсвийг хийлгэж, барьж эхлэх	1 суманд	Үерийн далан барьж эхэлсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	ХОХБТХ, ГХБХБГ
45	ЗДҮАХ-ийн 2.5.2.6 дахь заалт	Нийтийн эзэмшлийн зам, талбайн шаардлагатай цэгүүдэд стандартад нийцсэн нийтийн бие засах газруудыг байгуулах	Байгуулсан тоогоор	Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдсэн байна.	Орон нутгийн төсөв	ХОХБТХ, Арвайхээр сумдын ЗДТГ
46	ЗДҮАХ-ийн 1.1.2.7 дахь заалт	Хужирт сумын цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулах	Цэвэрлэх байгууламжийн ажил эхэлсэн байна.	Сумын иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөл бүрдэнэ.	Азийн хөгжлийн банк	ХОХБТХ, ГХБХБГ

47	ЗДҮАХ-ийн 2.5.1.2 дахь заалт	Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд автозам шинээр барих	Замын ажлын гүйцэтгэлээр	Шинэ суурьшлын бүс авто замаар холбогдсон байна.	Улсын төсөв	ХОХБТХ
48	ЗДҮАХ-ийн 2.5.1.5 дахь заалт	Зарим сумдын төвийг улсын чанартай хатуу хучилттай авто замтай холбох эскиз зураг хийлгэх, замын трассыг тогтоох	Ажлын хэрэгжилтээр	Замын трассыг тогтоосон байна.	Авто замын сангийн хөрөнгө	ХОХБТХ
49	ЗДҮАХ-ийн 2.5.1.3 дахь заалт	Хужирт - Төвхөн хийд-Улаан цутгалан, Хархорин – Хужирт - Арвайхээр, "Арвайхээр– Баянгол-Сайхан-Овоо - Цогт-Овоо, Даланзадгад", Арвайхээр– Гурвантэс- Шивээхүрэн чиглэлийн авто замуудыг барих зураг төслийг боловсруулах	Ажлын гүйцэтгэлээр	Зураг төсөл боловсруулагдсан байна.	Улс, орон нутгийн төсөв	ХОХБТХ
ГУРАВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
Эрүүл мэнд, боловсрол, соёл, урлагийн ёс зүйт үйлчилгээг чухалчилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, нийгмийн хамгааллыг зорилтот бүлгүүдэд чиглүүлж, гэр бүлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.						
3.1. ЭРҮҮЛ МЭНД						
<i>Зорилт 8. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг хөдөө орон нутагт зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын нэгдмэл удирдлагыг хангаж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.</i>						
50	ЗДҮАХ 3.1.1.3 дахь заалт	Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд гепатитийн В, С вирусын илрүүлэг шинжилгээнд 15-аас дээш насны эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг үзлэг, шинжилгээ, эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	3000-аас доошгүй иргэнийг хамруулах	Нэн ядуу, эрүүл мэндийн даатгалгүй иргэд гепатитийн вирус илрүүлэх, ачаалал тоолуулах шинжилгээнд хамрагдсан байна.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс /цаашид НБХ гэх/, Эрүүл мэндийн даатгалын тасаг /цаашид ЭМДТ гэх/

51	ЗДҮАХ 3.1.4 дэх заалт	Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвийг гематологийн аппараттай болгох, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын лабораторийн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах	Тусламж үйлчилгээний багцад заасан шинжилгээний 70 доошгүй хувийг хийх	Лабораторийн шинжилгээ хийх чадавх сайжирсан байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ
52	ЗДҮАХ-ийн 3.1.6.3	Гадаад орнуудад мэргэжил дээшлүүлэх чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг туршлага судлуулах, сургах, дадлагажуулах	Эмч, мэргэжилтнүүдийг сургах	Эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар нэмэгдсэн байна.	Орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ
53	ЗДҮАХ-ийн 3.1.9.2	АШУҮИС-тай хамтран сэргээн засах, ариутгагч, клиникийн эм зүй, нийгмийн эрүүл мэнд, статистикийн чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах	Эмч, мэргэжилтнийг чадавхжуулсан байна.	АШУҮИС-ын сургалтад хамруулж, мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	Орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ
54	ЗДҮАХ-ийн 3.1.9.21 дахь заалт	Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмийн агуулахын барилгыг шинээр барих асуудлыг шийдвэрлэж, эмийг зохистой хэлбэрээр хадгалах, түгээх ажлыг сайжруулах	Зориулалтын агуулахын барилга барих	Эм хадгалах, түгээх орчин стандартад нийцсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ
55	ЗДҮАХ-ийн 3.1.8.	БОЭТ-д эмгэг нярайн тасгийг шинээр нээж, тусламж үйлчилгээг сайжруулах	5-аас доошгүй өрөө бүхий тасаг	Нярайн эндэгдлийн түвшин урд оноос буурсан байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ, БОЭТ
56	ЗДҮАХ-ийн 3.5.	Бат-Өлзий, Хужирт, Хайрхандулаан, Нарийнтээл, Богд, Хархорин, Бүрд, Сант сумдын эмчийн байрыг засварлах	8 суманд засвар хийх	Сумдын эмч нарын нөхцөл сайжирсан байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ
57	ЗДҮАХ-ийн 3.5.	Сант сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засвар хийх, Зүүнбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв, Уянга сумын Жаргалант багийн хүн эмнэлгийг	Засвар 4	Эрүүл мэндийн төвүүдийн орчин нөхцөлийг сайжруулсан байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, ЭМГ, БОЭТ

		цэвэр, бохирын системтэй болгох, Тарагт сумын Эрүүл мэндийн төвийн бохирын систем, Тарагт сум, Жаргалант багийн хүн эмнэлгийн цахилгааны монтажийг засварлах				
3.2. БОЛОВСРОЛ						
<i>Зорилт 9. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын авьяас, ур чадварыг хөгжүүлэн, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд бие даан суралцах, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.</i>						
58	ЗДҮАХ-ийн 3.2.1.1, 3.2.1.2, 3.2.1.3, 3.2.1.4 дэх заалт	Арвайхээр сумын "Тэмүүлэл эрдэм" сургуульд 240 хүүхдийн, 2 дугаар сургуульд 320 хүүхдийн хичээлийн байрны өргөтгөл, Сант суманд 240 хүүхдийн хичээлийн байр, Хужирт суманд 50 ортой цэцэрлэгийн барилга шинээр барих	Өргөтгөл 2, бага сургуулийн хичээлийн барилга1, цэцэрлэгийн барилга 1,	Ашиглалтад орсон барилгын тоо хүчин чадлын хэмжээгээр	Улсын төсөв	ХОХБТХ, БСУГ
59	ЗДҮАХ-ийн 3.2.2.1, 3.2.2.2 дахь заалт	Богд, Гучин-Ус сумын хичээлийн 1 дүгээр байрны их засвар, Арвайхээр сумын "Тэмүүлэл-эрдэм", Мэргэд, Хархорин сумын 2 дугаар сургууль, Тарагт, Өлзийт, Баян-өндөр сумдын сургуулийн дээврийн их засвар, Төгрөг, Тарагт сумдын сургуулийн гадна фассад, Арвайхээр сумын 1, Уянга сумын 1 дүгээр сургуулийн сантехник, Жаргалант багийн хичээлийн 1 дүгээр байр, Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн урлаг заал болон ангиудын хэсэгчилсэн засвар, Хужирт, Бүрд сумын ЕБС-ийн хичээлийн байранд их засвар хийх, Баянгол сумын	Засварын ажлын гүйцэтгэлийн хувиар	ЕБС, цэцэрлэг, урлаг заал, дотуур байранд засвар хийгдсэн байна.	Улсын төсөв	БСУГ, ГХБХБГ

		спортын хуучин заалыг урлаг заал болгон засварлах				
60	ЗДҮАХ-ийн 3.2.2.1, 3.2.2.2 дахь заалт	Арвайхээр сумын 8 дугаар цэцэрлэг, Тарагт, Хайрхандулаан сумдын цэцэрлэгийн дээвэр, Төгрөг сумын цэцэрлэгийн сантехник, Арвайхээр сумын 5, 9 дүгээр цэцэрлэгийн хэсэгчилсэн засвар, Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэгийн дотор их засвар, Хархорин сумын 3 дугаар цэцэрлэг, Нарийнтээл, Баруунбаян-Улаан сумдын цэцэрлэгт засвар хийх	Засварын ажлын гүйцэтгэлээр	Цэцэрлэгүүдэд засвар хийгдсэн байна.	Улсын төсөв	БСУГ, ГХБХБГ
61	ЗДҮАХ-ийн 3.2.2.3, 3.2.2.4 дэх заалт	Баянгол, Богд, Нарийнтээл, Есөнзүйл, Сант, Төгрөг, Бат-Өлзий, Өлзийт сумдын сургуулийн дотуур байрны их засвар, Баян-Өндөр сумын 80 хүүхдийн дотуур байрны дотор засвар, Арвайхээр сумын 2 дугаар сургууль, Бүрд, Сант, Төгрөг сумдын сургуулийн спорт зааланд засвар хийх	Засварын ажлын гүйцэтгэлийн хувиар	Тухайн сумдын дотуур байр, спорт зааланд засвар хийгдсэн байна.	Улсын төсөв	БСУГ, ГХБХГ
62	ЗДҮАХ-ийн 3.2.1.5 дахь заалт	Арвайхээр, Хархорин сумдад цэцэрлэгийн зуны бүлэг ажиллуулж, 4-6 сумын цэцэрлэгийг гэр цэцэрлэгээр хангах, хувийн хэвшлийн цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжих	Шинээр бий болсон цэцэрлэгийн тоогоор	СӨБ-д хамрагдалт нэмэгдэнэ.	Орон нутгийн төсөв	НБХ, БСУГ
63	ЗДҮАХ-ийн 3.2.2.5 дахь заалт	Сургууль, цэцэрлэгүүдийн цахилгаан, дулаан хангамж, цэвэр, бохир усны дэд бүтцийг үе шаттайгаар шинэчлэх	Засварын ажлын гүйцэтгэлийн хувиар	Сургууль, цэцэрлэгүүдийн дэд бүтэц шийдвэрлэгдсэн байна.	Улсын төсөв	ХОХБТХ, БСУГ

64	ЗДҮАХ-ийн 3.2.3.1 дэх заалт	ЕБС-иудын кабинетүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Кабинет, тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоогоор	ЕБС-ийн кабинет тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Улсын төсөв	БСУГ
65	ЗДҮАХ-ийн 3.2.4.1 дэх заалт	Боловсролын байгууллагуудыг цахим тоног төхөөрөмж, ухаалаг самбар, техник хэрэгсэл, хатуу зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, тоглоом, наадгайгаар хангах	10-аас доошгүй сургууль	Шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Улс, орон нутгийн төсөв	БСУГ
66	ЗДҮАХ-ийн 3.2.4.2 дахь заалт	Зарим сургууль, цэцэрлэгийг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох	Ариун цэврийн байгууламжтай болсон сургууль, цэцэрлэгийн тоогоор	ЕБС, цэцэрлэгүүд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон байна.	Улсын төсөв	БСУГ
67	ЗДҮАХ-ийн 3.2.4.3 дахь заалт	Зарим ЕБС-ийг спорт, хөл бөмбөгийн талбайтай болгох, биеийн тамирын хэрэглэгдэхүүнээр хангах	Спорт, хөл бөмбөгийн талбайтай болсон сургуулийн тоогоор	Стандартын хөл бөмбөгийн талбай, биеийн тамирын хэрэглэгдэхүүнээр хангагдсан байна.	Улсын төсөв	БСУГ
68	ЗДҮАХ-ийн 3.2.4.4 дэх заалт	Нарийнтээл сумын Баянтээг, Уянга сумын Жаргалант багийн ЕБС, цэцэрлэгүүдийг интернет сүлжээнд холбох	Холбогдсон байгууллагын тоогоор	Тухайн сургууль, цэцэрлэгүүдэд сурах орчин бүрдсэн байна.	Улсын төсөв	БСУГ
69	ЗДҮАХ-ийн 3.2.8.1 дахь заалт	Аймгийн хэмжээнд Насан туршийн боловсролын нэгжийн багш-арга зүйчдийг шаардлагатай техник хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг сайжруулах, өндөр хурдны интернэттэй холбох, Уянга, Бүрд, Сант, Зүүнбаян-Улаан зэрэг сумдын Насан туршийн боловсролын нэгжийг танхимаар хангаж, вэйб сайттай болгох	Сумын насан туршийн боловсролын нэгжийн тоогоор	Насан туршийн боловсролын нэгжүүдийн багш, арга зүйч нарын нийгмийн баталгаа хангагдсан байна.	Орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Насан туршийн боловсрол төв /цаашид НТБТ гэх/, холбогдох сумдын ЗДТГ

70	ЗДҮАХ-ийн 3.2.3.1 дэх заалт	Техник, технологийн улсын олимпиадыг аймагт зохион байгуулах	Оролцогчдын тоогоор	Багш, сурагчдын техник, технологийн мэдлэг дээшилнэ.	Улс, орон нутгийн төсөв	БСУГ
71	ЗДҮАХ-ийн 3.2.7.1 дэх заалт	Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг эцэг, эхийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар ханган, дэмжиж ажиллах	Оролцогчдын тоогоор	Тэгш хамруулах боловсролын талаар эцэг эх, хүүхдүүдийн ойлголт мэдлэг нэмэгдсэн байна.	Японы хүүхдийг ивээх сангийн боловсролын төсөл	БСУГ, НТБТ
72	ЗДҮАХ-ийн 3.2.4.1 дэх заалт	Зарим сургууль, цэцэрлэгийг хүнсний бүтээгдэхүүн хадгалах хөргүүрээр хангах, үдийн хоол үйлдвэрлэх тогооч нарыг чадавхжуулах, сургаж, дадлагажуулах	Сургуулиудын тоогоор	Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн аюулгүй байдал хангагдсан байна.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ, ХХААГ, сумдын ЗДТГ
3.3. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ						
Зорилт 10. Соёлын байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлж, гадаад харилцааг өргөжүүлэн, соёл, урлагийн үйлчилгээг аялал жуулчлалтай холбон сурталчилж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.						
73	ЗДҮАХ-ийн 3.3.1.1 дэх заалт	Соёл, урлагийн байгууллагуудыг хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	5-оос доошгүй байгууллага	Хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, БСУГ
74	ЗДҮАХ-ийн 3.3.1.4 дэх заалт	"Өвөрхангайн соёлын өдөр" арга хэмжээг сумдад зохион байгуулах	3 сум	Соёлын өдрүүд зохион байгуулагдсан байна.	Улс, орон нутгийн төсөв	НБХ, БСУГ
75	ЗДҮАХ 3.3.4.4 дэх заалт	Спортын ордны дотор засвар хийх, стандартад нийцсэн зориулалтын модон шалтай болгох, гэрэлтүүлгийг шинэчлэх	Ажлын гүйцэтгэлээр	Спортын ордны орчин, нөхцөл сайжирна.	Орон нутгийн төсөв	БТСГ
76	ЗДҮАХ 3.3.4.5. дахь заалт	Улсын аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнийг орон нутагтаа 1-2 удаа зохион байгуулах	Тэмцээн болон оролцогчдын тоогоор	Орон нутагтаа спортын төрлүүдийг сурталчилсан байна.	Орон нутгийн төсөв, спортын холбоод	БТСГ
77	ЗДҮАХ 3.3.4.5. дахь	Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат	Тэмцээн уралдааны тоогоор	Тамирчдын ур чадвар, амжилт	Орон нутгийн төсөв, спорт	БТСГ

	заалт	дасгалжуулагч Ч.Насантогтохын нэрэмжит жүдо бөх, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангийн нэрэмжит шатрын тэмцээнүүдийг орон нутагтаа зохион байгуулах		өсөж, спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ.	холбоод	
78	ЗДҮАХ-ийн 3.3.1.2 дахь заалт	Баянгол сумын Соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулах, аймгийн Музейн барилгын ажлыг эхлүүлэх, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан сумдын Соёлын төвийн дээврийн засвар, Өлзийт сумын Соёлын төв, Төв номын сангийн барилгад засвар хийх	2 суманд шинээр барих, 3 суманд засвар	Соёлын төв, номын сангийн үйлчилгээний орчин нөхцөл сайжирсан байна.	Улсын төсөв	ХОХБТХ, БСУГ, ГХБХБГ
79	Аймгийн ЗДҮАХ-ийн 3.3.3.4 дэх заалт	Төв халхын алдарт уртын дуучин МУГЖ С.Сумъяа агсны нэрэмжит Уртын дууны аймгийн YII, морин хуурч МУСТА Д.Цэрэнжигмэдийн нэрэмжит морин хуурчдын аймгийн III уралдааныг тус тус зохион байгуулах	2 уралдаан зохион байгуулах	Төв халхын биет бус өв хойч үед өвлөгдөн уламжлагдсан байна.	Орон нутгийн төсөв, Хандивлагч	НБХ, БСУГ, ХДТ
80	ЗДҮАХ-ийн 3.3.1.5 дахь заалт	Мэргэжлийн урлагийн байгууллагыг бодлогоор дэмжиж, шинэ уран бүтээл тавих, уран бүтээлчдийн хувцасыг шинэчлэх	Шинэ уран бүтээлийн тоогоор	Уран бүтээлийн чанар дээшилж, үйлчилгээний цар хүрээ өргөжнө.	Орон нутгийн төсөв	БСУГ, ХДТ
3.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ						
Зорилт 11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар 10 мянгаас доошгүй ажлын байр бий болгоно.						
81	ЗДҮАХ-ийн 3.4.1 дэх заалт	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээлэл өгөх, ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл, хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр 2500 ажлын байр бий болгох	Шинээр 1500 ажлын байр, түр 1000-аас дээш ажлын байр	Шинээр ажлын байр бий болж иргэдийн амьжиргаа дээшилсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /цаашид ХХҮГ гэх/

82	ЗДҮАХ-ийн 3.4.1.2 дахь заалт	"Нэг өрх-нэг ажлын байр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-үүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Арвайхээр суманд бизнес инкубаторын төв байгуулах	Хөтөлбөрийн тухай жилийн төлөвлөгөөний биелэлт 80 хувиас дээш байх	Зорилтот бүлгийн өрхүүдийн нэг гишүүн байнгын ажлын байртай болсон байна	Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
83	ЗДҮАХ-ийн 3.4.1.4 дэх заалт	Хөдөлмөрийн хөлсний бүрэн олголтын байдалд хяналт тавих орон тооны бус зөвлөл, мэргэжлийн холбоодтой хамтран хяналт, шалгалтыг зохион байгуулах	Төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд	Хөдөлмөрийн хөлсний талаарх зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	Улс, орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс /цаашид ХЭЗХ гэх/, НБХ, ХХҮГ
84	ЗДҮАХ-ийн 3.4.3.4 дэх заалт	"Мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, дадлагажуулахад нийгмийн түншлэлийг хөгжүүлэх нь" аймгийн зөвлөгөөн зохион байгуулах	Төрийн болон хувийн хэвшлийн 100 байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл	Төр, хувийн хамтын ажиллагаа сайжирсан байна.	Улс, орон нутгийн төсөв, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	НБХ, ХХҮГ
85	ЗДҮАХ-ийн 3.4.2.1 дахь заалт	Политехник коллежийг түшиглэн хөдөө аж ахуйн иж бүрэн дадлагын газрыг бий болгох	Дадлагын газартай болсон байна.	Чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэгдэх нөхцөл бүрдсэн байна.	Улсын төсөв, Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	НБХ, ХХҮГ
3.5. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛ						
Зорилт 12. "Хүүхдэд ээлтэй аймаг" хөтөлбөр хэрэгжүүлж, хүүхдийн хүмүүжил төвөвшилд анхаарч, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна.						
86	ЗДҮАХ-ийн 3.5.1.2 дахь заалт	Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд "Залуус хөгжлийн танхим"-ыг тохижуулах	Танхим байгуулсан байна.	Залуучуудад чиглэсэн хөгжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлсэн байна.	Орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /цаашид ГБХЗХГ гэх/
87	ЗДҮАХ-ийн 3.5.2.4 дэх	"Миний урлан" хүүхдийн бүтээлийн наадмыг зохион	Хэрэгжилтээр	Бүтээлийн наадмыг зохион байгуулсан	Орон нутгийн төсөв	ГБХЗХГ

	заалт	байгуулах		байна.		
88	ЗДҮАХ-ийн 3.5.2.4 дэх заалт	Гэр бүлийн хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, сэтгэл засал, нөхөн сэргээх зэрэг цогц үйлчилгээг үзүүлж, тайвшруулах, нэг цэгийн үйлчилгээг цогцоор хүргэх мэргэжилтэн бэлтгэх	Орон тооны боловсон хүчинтэй болсон байна.	Хамгаалах байранд байрлаж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийн аюулгүй байдал хангагдсан байна.	Орон нутгийн төсөв	ГБХЗХГ
89	ЗДҮАХ-ийн 3.5.2.1 дэх заалт	Гэрлэх насны болон шинээр гэр бүл болж буй залуучуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэрлэлтийг хариуцлагажуулах зорилгоор "Амьдралд тавтай морил" багц сургалтын модулийг хэрэгжүүлэх	500 доошгүй шинэ гэр бүл	Сургалтын модуль хэрэгжсэнээр гэр бүлийн гүшүүд үүрэг, хариуцлагаа ухамсарласан байна.	-	НБХ, ГБХЗХГ
3.6. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ						
Зорилт 13. Нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.						
90	ЗДҮАХ-ийн 3.6.1.3 дахь заалт	Эрсдэлт нөхцөлд байгаа нийгмийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдийн сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, нийгэмшүүлэх, амьдрах ухааны сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх, тусгайлсан арга хэмжээ зохион байгуулах	Зорилтот бүлгийн 250-аас дээш иргэн хамрагдсан байна	Иргэдийн сэтгэлгээ хандлага өөрчлөгдсөн байна	Улс, орон нутгийн төсөв,	ХХҮГ
Зорилт 14. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр хамрагдалтыг нэмэгдүүлнэ.						
91	ЗДҮАХ-ийн 3.6.2.1 дэх заалт	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, нийгмийн баталгааг хангах	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоогоор	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн баталгаа хангагдана.	Улсын төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтэс /цаашид НДХ гэх/
92	ЗДҮАХ-ийн	Нийгмийн даатгалын шимтгэл	Архивын	Архивын үйлчилгээ	Улсын төсөв	НДХ

	3.6.2.2 дахь заалт	төлөлтийн тайланг бүрэн цахимжуулж, цахим архивын мэдээллийн санг бүрдүүлэх	лавлагааны тоогоор	хэрэглэгчдэд түргэн шуурхай хүрсэн байна.		
93	ЗДҮАХ-ийн 3.6.2.2 дахь заалт	"Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох" тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулах	Шинээр хамрагдсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоогоор	Хууль хэрэгжсэн байна.	Улсын төсөв	НДХ
94	ЗДҮАХ-ийн 3.6.2 дахь заалт	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсролын магадлах нүүдлийн хурлыг сумдад хуваарийн дагуу зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сумдад зохион байгуулагдсан хурал байна.	Улсын төсөв	НДХ
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУД						
Хууль нэг мөр хэрэгждэг, хүн бүрт төрийн үйлчилгээ эрх тэгш, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.						
4.1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ						
<i>Зорилт 15. Төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд шаардлага хангахгүй хариуцлага алдаж, ёс зүйн алдаа гаргасан төрийн албан хаагчдад хууль журмын дагуу хариуцлага тооцож, төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</i>						
95	ЗДҮАХ-ийн 4.1.3 дэх заалт	"Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил" аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх	Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоогоор	Төрийн албан хаагчдыг үе шаттайгаар сургалтад хамруулсан байна.	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ, ТАСЗ
96	ЗДҮАХ-ийн 4.1 дэх заалт	Аймаг, сумдын "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлэх	Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоогоор	Иргэдэд төрийн үйлчилгээг чанартай, ил тод хүргэсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	Сумдын ЗДТГазар
<i>Зорилт 16. Сумдын ИТХ, ЗДТГ-ын материаллаг бааз, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.</i>						
97	ЗДҮАХ-ийн	Хайрхандулаан сумын ЗДТГ-ын барилгыг	1 сумын	Барилга	Улс, орон	Аймаг, сумдын

	4.1.2.1 дэх заалт	ашиглалтад оруулах	ЗДТГ-ын барилга	баригдсан байна.	нутгийн төсөв	ЗДТГ
98	ЗДҮАХ-ийн 4.1.3.1 дэх заалт	Баянгол, Богд сумдад багийн төвүүдийн барилга шинээр барих	Багийн төвийн барилгын тоогоор	Хөдөөгийн багийн төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Улсын төсөв	Аймаг, сумдын ЗДТГ
99	-	Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт, Арвайхээр сумдын төрийн зарим байгууллагуудын барилгад их засвар хийх	Их засварын тоогоор	Төрийн албан хаагчдын ажиллах орчин сайжирна.	Улсын төсөв	Аймаг, сумдын ЗДТГ
Зорилт 17. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнд суурилж, төрийн байгууллагуудын үйлчилгээ болон менежментийг сайжруулах, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.						
100	АЗДҮАХ-ийн 2.1.3	Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Орон нутагт хэрэгжиж дууссан 14 бодлогын баримт бичигт үнэлгээ хийлгэх	Бодлогын баримт бичгүүдийн үр дүн, үр нөлөөг дүгнэж, төлөвлөлтөд чиглэсэн зөвлөмж гарсан байна.	Орон нутгийн төсөв	ХШУДАХ
Зорилт 18. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, цэргийн насны залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил олгох төлөвшлийн орчинг бүрдүүлнэ.						
101	АЗДҮАХ-ийн 13.1 дэх заалт	Өвөрхангай аймгаас төрсөн генерал цолтнуудад хүндэтгэлийн танхим, талбай тохижуулж, олон нийтэд эх оронч үзэл, хүмүүжил олгох	Танхим, талбай байгуулагдсан байна.	Хүүхэд, залуучууд, иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил олгосон байна.	Орон нутгийн төсөв	Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, ХОХБТХ
4.2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ						
Зорилт 19. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, сум бүрт хууль зүйн туслалцааны бие даасан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
102	ЗДҮАХ-ийн 4.2.1.2 дахь заалт	Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийн орон нутагт хамааралтай зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх	Хэрэгжилтээр	Орон нутагт хамааралтай зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Орон нутгийн төсөв	ХЭЗХ

103	АЗДҮАХ-ийн 4.1.8 дахь заалт	Байгууллагуудын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх	Цахим архив үүссэн байх	Архивын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх боломж бүрдэнэ.	Улс, орон нутгийн төсөв	ХЭЗХ, Архивын тасаг
104	ЗГҮАХ-ийн 5.1.17 дахь заалт	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэж, цахим засгийг бодитой хэрэгжүүлж, бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдоогүй сумдыг холбох	6 сум	Иргэдэд газар дээр нь чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх боломжтой болно.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн хэлтэс /цаашид УБХ гэх/
<p>Зорилт 20. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хангахад хуулийн байгууллагуудын хамтын хүчин чармайлтыг чиглүүлж, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг судалж, нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>						
105	ХЗДХСайдын гэрээний 3.3.2	Цагдаагийн сургалтын төвийг Хангайн бүсийн төв болгон өргөжүүлэхэд техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх	Техник, хэрэгслийн хангамжаар	Хангайн бүсийн сургалтын төв болгон өргөжиж техник хэрэгслээр хангагдсан байна.	Орон нутгийн төсөв	Аймгийн Цагдаагийн газар
106	ЗДҮАХ-ийн 4.2. дахь хэсэг	Шүүхийн шинжилгээний албаны албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, байрны гадна тохижилтыг сайжруулах, интернетийн шилэн кабельд холбох, халаалтын шугам сүлжээ, цахилгааны монтажид засвар, үйлчилгээ хийх, шинэчлэх	Засвар үйлчилгээ, тохижилт хийгдсэн байна.	Албаны байр, ажиллах нөхцөлөөр хангагдсан байна.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн Шүүхийн шинжилгээний алба
<p>Зорилт 21. Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, аймгийн хөгжлийг дэмжих “Стандарттай Өвөрхангай” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>						
107	ЗДҮАХ-ийн 4.1.12 дахь заалт	Цахилгаан эрчим хүчний хэмжилтийн эталон төхөөрөмжөөр ханган, иргэдэд хүргэх үйлчилгээг чирэгдэлгүй болгох	Үйлчилгээ хийгдсэн байна.	Үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтэс

4.3. ОНЦГОЙ БАЙДАЛ

Зорилт 22. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, аврах бүлэг, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын сургалт, дадлагыг тогтмолжуулна.

108	ЗДҮАХ-ийн 4.1.2 дахь заалт	Хужирт сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн байр, автомашины граж, автомашин, аврах ажиллагааны нисгэгчгүй нисэх төхөөрөмж, зургийн аппаратаар хангах	Аврах бүлэг ажиллах нөхцөлөөр хангагдсан байна.	Эрэн хайх аврах бүлэг аврах ажиллагааг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах нөхцөл бүрдсэн байна.	Улс, орон нутгийн төсөв	Аймгийн Онцгой байдлын газар /цаашид ОБГ гэх/
-----	----------------------------------	--	---	--	----------------------------	---